



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 1/31

Хархорин сум

Г Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Соёмбо хороолол 5 тоотод иргэн “Номадс өргөө” ХХК урлаг соёлын үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа 6209008178 нэгж талбарын дугаартай 5000м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв, цогцолборийн зориулалттай болгон өөрчилсүгэй.

2. Газар эзэмшигч “Номадс өргөө” ХХК-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (захирал Ж.Дайрийжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ



401100363